

**“МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ
ХЭРЭГЖИЛТЭД ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

2023.12.25

НЭГ. ЗОРИЛГО

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-нд туссан Барилга, хот байгуулалтын Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2023 оны байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санал, зөвлөмж хүргүүлэх, холбогдох байгууллага, албан тушаалтанд бодит мэдээлэл өгөх, төрийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хариуцлагыг сайжруулах, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Засгийн газрын 2021 оны 374 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу “Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг зорилтот түвшин, шалгуур үзүүлэлттэй уялдуулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж хүргүүлж байна.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

“Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-нд туссан Барилга, хот байгуулалтын Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 3 бодлого, 8 зорилгын хүрээнд нийт 34 арга хэмжээ, үүнээс 15 арга хэмжээний үндсэн хэрэгжүүлэгчээр, 19 арга хэмжээний хамтран хэрэгжүүлэгчээр ажилласан байна.

“Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд **95,59%-тай**, “**тодорхой үр дүнд хүрсэн**” гэж үнэллээ.

Хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт 34 арга хэмжээнээс хэрэгжилт 100%-тай 29, 90% -3; 70%-тай -0; 50%-тай -1; 30%-тай -1 арга хэмжээ байна.

Хэрэгжилт хангалтгүй, 30 хувьтай арга хэмжээ 1 байна. Үүнд:

1. Арга хэмжээ 5.1.1.5. Улаанбаатар хотын гэр хорооллыг дахин төлөвлөж, орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх төслүүд хэрэгжүүлэх.

Шалгуур үзүүлэлт: "Солонго-1", "Солонго-2" орон сууцны хороолол барих төслийн явц, хувиар -50%

Хэрэгжилтийг эрчимжүүлэх, 50 хувьтай арга хэмжээ 1 байна. Үүнд:

1. Арга хэмжээ 5.2.1.2. Орон нутаг дахь сум, суурин газрын ус хангамж, ариутгах татуурга, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх ("Сумын хөгжил" арга хэмжээний хүрээнд инженерийн дэд бүтэц байгуулах сумын тоо)

Шалгуур үзүүлэлт: "Сумын хөгжил" арга хэмжээний хүрээнд инженерийн дэд бүтэц байгуулах сумын тоо-18

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Монгол Улсын Их хурлын 2022 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-нд туссан Барилга, хот байгуулалтын Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 34 арга хэмжээний хэрэгжилтэд 2023 оны байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилт **95,59 хувь**, “**тодорхой үр дүнд хүрсэн**” гэж дүгнэж байна.

ДӨРӨВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд туссан хэрэгжилт хангалтгүй 0-50%-тай 2 арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх;
2. Цаашид яамны бүх газар, хэлтсүүд төлөвлөлтөө сайжруулан, Монгол Улсын хөгжлийн дараа жилүүдийн төлөвлөгөөг боловсруулахдаа зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан оновчтой, зөв тодорхойлох, хэрэгжилтийн тайланг үнэн зөв, тодорхой, зарцуулсан хөрөнгө, нотлох баримтын хамт тогтоосон хугацаанд нь МХШҮГазарт ирүүлж хэвшихийг яамны газар хэлтсүүдэд даалгах нь зүйтэй гэсэн зөвлөмжийг хүргүүлж байна.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ